

Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил

Хувилбар -13

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
 2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
 3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (А.)
 - Зөв, Зөв, Буруу (В.)
 - Зөв, Буруу, Буруу (С.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)
- /1./ Анхдагч сүрьеэгийн үед үүссэн шүүдэст плевритын хувьд дараахаас бусад нь онцлог байдаг
- A. Залуу насанд илүүтэй тохиолдоно
 - B. Сүрьеэгийн эсрэг эмчилгээг гялтангийн хөндийд шингэн байх үед л хийнэ
 - C. Экссудат серозон шинжтэй
 - D. Шингэнд лейкоцит цөөн, лимфоцит давамгайлна
 - E. Уушгинд өөрчлөлт илрээгүй байна
- /2./ Буруу тодорхойлолтыг сонгоно уу
- A. Амьсгаадалт нь уушгины архаг бөглөрөлт өвчний үндсэн шинж мөн
 - B. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед амьсгаадалт зөвхөн ачааллын үед илэрнэ
 - C. Амьсгаадалт нь ихэнх өвчтөн эмнэлэгт хандах шалтгаан болдог
 - D. Амьсгаадалтын улмаас өвчтөн албадмал байрлалд орж болно
 - E. Амьсгалын замын халдвар амьсгаадалтыг сэдрээж болно
- /3./ Мантугийн сорилыг тавихдаа туберкулиныг яаж хэрэглэх вэ?
- A. Цагаан мөгөөрсөн хоолойд цацна
 - B. Арьсанд тарина
 - C. Арьсан дор тарина
 - D. Судсанд тарина
 - E. Арьсан дээр хэрэглэнэ
- /4./ Анафилаксийн үед медиаторууд ямар эсээс ялгарах вэ?
- A. Эозинофил
 - B. Т-лимфоцит
 - C. Цулцангийн макрофаг
 - D. В-лимфоцит
 - E. Хөөнгө эс
- /5./ Дараахаас аль нь үнэн бэ?
- A. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед ингаляцийн кортикостероиддыг дангаар \удаан үйлдэлтэй гуурсан хоолой тэлэгч эмгүй\ хэрэглэхийг зөвлөхгүй
 - B. Ингаляцийн кортикостероидыг $FEV1 \geq 80\%$ өвчтөнд хэрэглэнэ
 - C. Хүндэвтэр зэргийн уушгины архаг бөглөрөлт өвчинтэй хүнд удаан хугацааны туршид системийн кортикостероид хэрэглэнэ
 - D. Уушгины архаг бөглөрөлт өвчний сэдрэлийн үед кортикостероидыг хэрэглэхгүй
 - E. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед ингаляцийн кортикостероидыг аль болох эрт хэрэглэнэ
- /6./ Уушгины үрэвслийн нийтлэг бус үүсгэгч юу вэ?
1. Микоплазм

2. Легионелл
 3. Хламиди
 4. Томуугийн вирус
 5. Цитомегаловирус
- /7./ Уушгины дэлбэнгийн үрэвслийн үед ямар шинж тодорхойлогдох вэ?
1. Амьсгал эрс сулрах, эсвэл сонсогдохгүй байх
 2. Бронхофони ба дууны доргион ихсэх
 3. Тогшиход хэргэргэн дуутай байх
 4. Гуурсан хоолойн амьсгал сонсогдох
 5. Бронхофони ба дууны доргион сулрах
- /8./ Гуурсан хоолой тэлэгдэх өвчний эмчилгээний үндсэн аргыг нэрлэнэ үү:
1. Байрлалын дренаж
 2. Хордлого тайлах
 3. Доргионт массаж
 4. Дархлаа дэмжих
 5. Цэр шингэлэх
- /9./ Цээжний хөндийн хоёр талын лимфаденопати ямар өвчний үед илэрч болох вэ?
1. Саркоидоз
 2. Лимфогранулематоз
 3. Лимфом
 4. Гистицитоз Х
 5. Силикоз
- /10./ Уушгины сүрьеэ үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл бол:
1. Ходоод, дээд гэдэсний шархлаа
 2. Чихрийн шижин
 3. Силикоз
 4. Лимфогранулематоз
 5. Артерийн гипертензи
- /11./ Хүүхэд шөнө орондоо шээхийг юу гэж нэрлэх вэ?
- A. Олигоури
 - B. Дизури
 - C. Никтури
 - D. Странгури
 - E. Энурез
- /12./ Гликокаликс гэж аль ойлголтыг нэрэлдэг вэ
- A. Подоцитийн элемент
 - B. Мезангиумын элемент
 - C. Суурин мембраны хасах цэнэгтэй хэсгүүд
 - D. Ялгаруулах аппарат
 - E. Ренин
- /13./ Хоёрдогч пиелонефритийн үед доорхи шинжүүдээс нэгээс бусад нь илрэнэ
- A. Дизури
 - B. 1мл шээсэнд 100000-аас дээш нян илэрнэ
 - C. Бөөрний аяганцар тэвшинцэрийн деформаци
 - D. Түүдгэнцэрийн шүүлт буурах
 - E. Сувганцаэрын эргэн шимэгдэлт буурах
- /14./ Архаг гломерулонефритийн даралт ихдэх хэлбэрийн сэдрэлийн үед дараах нэг шинжээс бусад нь илэрнэ.
- A. Протеинури
 - B. Гематури
 - C. Цилиндрури
 - D. Хаван
 - E. Артерийн даралт ихсэлт
- /15./ Доплерт сонографи дараахь тохиолдлоос нэгээс бусдад хийх шаардлагатай.
- A. Бөөрний хавдар
 - B. Шалтгаан тодорхойгүй шээс цустах

C. Шалтгаан тодорхойгүй даралт ихсэх

D. Архаг гломерулонефрит

E. Бөөрний унжилт

/16./ Бөөрний цочмог дутагдлын үед зайлшгүй хийх шинжилгээг нэрлэнэ үү?

1. Цусан дах креатинин

2. Цусны PH үзэх

3. Цусны электролит үзэх

4. Зимницкийн сорил

5. Шээсэн дэх давсны агууламж

/17./ Архаг гломерулонефритийн үед гормон эмчилгээ хийх заалт

1. Гематури

2. Артерийн даралт ихсэлт

3. Бөөрний архаг дутагдал

4. Нефроз хам шинж

5. Сэдрэлээс сэргийлэх зорилгоор

/18./ Транзитор уураг алдалт нь дараах тохиолдолд илрэнэ

1. Биеийн эмгэг галбир

2. Даарч хөрөх

3. Биеийн хүчний хүнд ажил хийх

4. Удаан хугацаагаар халуурах

5. Фитнес хийх

/19./ Бөөрний цочмог дутагдалын үед зайлшгүй хийх лабораторын шинжилгээ

1. Шээсний нянгийн шинжилгээ

2. Цусан дах креатинины хэмжээ

3. Нүдний уг дурандах

4. Цусны электролит үзэх

5. Цусны PH үзэх

/20./ БАӨ-ий 1-2р үе шатанд лабораторын шинжилгээгээр хянах үзүүлэлт

1. Шээсний хүчил

2. Креатинин

3. Электролит

4. Өлөн үеийн сахар, липид

5. ТШХ

/21./ Архаг гломерулонефритын нефротик хэлбэрийн идэвжлийн үед бөөр хамгаалах эмчилгээний багцыг хэрэглэнэ. Стероид үйлдэлтэй үрэвслийн эсрэг эмийг дундчаар 1 сар хэрэглэнэ

/22./ БАӨ-өөр өвдөх эрсдэл өндөртэй хүмүүсийг илрүүлэн хянах нь чухал. Хянахдаа 12 сард 1 удаа хяналтын үзлэг хийхийн зэрэгцээ жилд 2-3 удаа хэвтүүлж эмчилснээр БАӨ-г сэргийлэх боломжтой болдог.

/23./ Доорх өөрчлөлтүүд илэрсэн нойр булчирхайн цочмог үрэвсэл бүхий үйлчлүүлэгчийн аль үзүүлэлт үйлчлүүлэгчийн тавилан муу байгааг болон нас барах эрсдлийг нэмэгдүүлж байна вэ?

A. БЖИ >25 кг/м²

B. Гематокрит >40%

C. Липаза >1000IU/l

D. PaO₂<60ммуб

E. Цагаан эсийн тоо >10,000

/24./ Асцитийн шингэнд нейтрофил эсийн тоо >250 мм³ тохиолдолд ямар эмгэгийг сэжиглэх вэ?

A. Сүрьеэгийн шалтгаантай асцит

B. Хавдарын шалтгаантай асцит

C. Аяндаа үүсэх перитонит

D. Зүрхний дутагдлын шалтгаантай асцит

- Е. Элэгний циррозын шалтгаантай асцит
- /25./ Бүдүүн гэдэсний архаг үрэвслийн үед олонтаа хэрэглэх эмийн бэлдмэл
- А. Нян устгах бэлдмэл, сульфазалазин, делагил, витамин
 - В. Нян устгах бэлдмэл, бактерийн бэлдмэл, хөдөлгөөний зохицуулагч фермент
 - С. Бактерийн бэлдмэл, суулгалт зогсоох бэлдмэл, агчилт тавиулах болон өвдөлт намдаах эм, бодисын солилцоог эрчимжүүлэгч
- /26./ С вирусын эсрэг эмчилгээ хийх явцад эмчилгээний хяналтын шинжилгээг хэзээ хийх вэ?
- А. Гематологи сард 2 удаа, биохими сард нэг, вирусологи эмчилгээний эхлэл болон төгсгөлд, гистологи нэг удаа
 - В. Гематологи сард нэг, биохими сард 2, вирусологи сард 1, гистологи сар тутам
 - С. Гематологи 2 долоо хоног тутамд, биохими 4 долоо хоног тутам, вирусологи 3 сар тутам, гистологи 6-12 сарын дараа
- /27./ Элгэнд аммиак холбогдон хувирахыг идэвхжүүлэх үйлдэлтэй эмийг сонгоно уу?
- А. Эссенциаль
 - В. Гептрал
 - С. Гепта-мерз
 - Д. Гемодез
 - Е. Неоминопагин
- /28./ Улаан хоолойн тархмал агшилтыг үүсгэх хоёрдогч шалтгаануудыг сонгоно уу?
- 1. Ходоод улаан хоолойн сөөргөө өвчин
 - 2. Улаан хоолойн үрэвсэл
 - 3. Өрцний ивэрхий
 - 4. Ходоод дээд гэдэсний шархлаа өвчин
 - 5. Цөсний чулуу
- /29./ Цөс нойр булчирхайн сувгийг сэтгүүрдэх шинжилгээний тусламжтайгаар хийж болох нэмэлт оношлогоог нэрлэнэ үү
- 1. Биопси
 - 2. Цитологи
 - 3. Холедохоскопи
 - 4. Панкреатикоскопи
 - 5. Хавдрын маркер тодорхойлох
- /30./ Гистамины H₂ рецепторыг хориглогч 3-р үеийн эмийн бэлдмэлийг сонгоно уу?
- 1. Цемитидин
 - 2. Ранитидин
 - 3. Зантак
 - 4. Фамотидин
 - 5. Роксатидин
- /31./ Литотрипси хийсний дараа ямар хүндрэл гарах вэ?
- 1. Цөсний ерөнхий цорго гэмтэх
 - 2. Транзитор цөсний хатгаа
 - 3. Цөсний ерөнхий сорвижих
 - 4. Панкреатит
 - 5. Цөсний хүүдий цоорох
- /32./ Цитолизыг заадаг параметруудийг сонгоно уу?
- 1. ЛДГ
 - 2. Билирубин
 - 3. АСАТ
 - 4. Альбумин
 - 5. Шүлтлэг фосфатаз
- /33./ Асцитын шингэний эргэн шимэгдэх чадвар дээд тал нь 700-900мл/хоногт байдаг учир диуретик эмчилгээний үед биеийн жингийн бууралт өдөрт 750гр-аас ихгүй байх ёстой.

/34./ Дээд гэдэсний дамжуулалт алдагдах нь нугалуурын клапан, том хөхлөгийн агшилт үүсгэх учир дээд гэдэсний агуулагдахуун эргээд цөсний зам руу хаягдан халдвар орох нөхцлийг бүрдүүлж халдварын гаралтай холецистит үүснэ

/35./ Ямар үед бамбай булчирхайн 1-р зэргийн томрол гэх вэ?

- A. хажуугийн эрхтнээ дарсан
- B. нүдэнд харагдана
- C. нүдэнд харагдана, тэмтрэгдэнэ
- D. тэмтрэгдэнэ, харагдахгүй
- E. тэмтрэгдэхгүй, харагдахгүй

/36./ Гипогликемийн комын үед дараах тохиолдолд тархи хавагнасан гэж үзнэ.

- A. Таталт илэрвэл
- B. Дэмийрч солиорвол
- C. Хүүхэн хараа өргөсвөл
- D. Цусны глюкоз 6.0 ммоль/л хүртэл өссөн боловч ухаан орохгүй бол
- E. Цусны глюкоз 3.0 ммоль/л-ээс их болсон ч ухаан сэргэхгүй бол

/37./ Тархмал хордлогот бахуугийн үед зүрх судасны талаас илрэх эмнэлзүйн шинжийг сонгоно уу

- A. Артерийн даралт багасах
- B. Зүрхний хэм алдагдал
- C. Атеросклероз
- D. Перикардийн хөндийд шингэн хуримтлагдах
- E. Тиреотоксикозын миопати

/38./ Глюкагон дараах үйлдэлтэй.

- A. Липолизыг багасгана
- B. Гексокиназа ферментийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ
- C. Гликогенезийг ихэсгэнэ
- D. Глюконеогенезийг багасгана
- E. Гликогенолизыг ихэсгэнэ

/39./ Таргалалтын эмчилгээг сонгоно уу

- A. Хоол эмчилгээ
- B. Хөдөлгөөн эмчилгээ
- C. Эмийн эмчилгээ
- D. Мэс заслын эмчилгээ
- E. Дээрх бүгд орно

/40./ ЧШ-тэй эмчлүүлэгчид инсулины тун багадсанаас цусны глюкоз ихэсдэг. Хэрэв инсулины тунг тохируулахгүй бол энэ юунд хүргэх вэ?

1. Их шээнэ
2. Усгүйжилт улам гүнзгийрнэ
3. Бөөлжинө
4. Кетоацидозод орно
5. Амнаас ацетон үнэртэнэ

/41./ 2-р хэлбэрийн ЧШ-ий шалтгаан

1. Удам зүйн урьдчилсан байдал: HLA B15, DR4, DRw4, DQB1*0302, DQA1*0301
2. Вирус: Коксаки B4, улаанууд, паротит
3. Удам зүйн урьдчилсан байдал: HLAB8, DRw3, DQB1*0201, DQA1*0501
4. Удам зүйн урьдчилсан байдал: HLA-тэй холбоогүй
5. β эс ба арлын эсрэг антител үүсэх

/42./ Чихрийн шижингийн үед глюкозжсон гемоглобин нэмэгддэг. Учир нь ЧШ-гийн үед цусан дахь глюкозын түвшин удаан хугацаагаар өндөр байдаг.

/43./ 1 мл гепарины уусмал хэдэн нэгж гепарин байдаг вэ?

- A. 5000
- B. 1000
- C. 10000

D. 15000

E. 1500

/44./ Анхдагч артерийн гипертензийн үед ЗЦБ –р илрэх зүүн ховдлын томролын Лион-Соколовын шинж тэмдэгийг заах

A. $Rv5 > 25\text{мм}$

B. $Sv3 + Rv1 > 24\text{ мм}$

C. $Rv4 > Rv5$

D. $Rv5 + Sv1 > 30\text{мм}$

E. $Rv5 + Sv1 > 35\text{мм}$

/45./ ЗЦШ-ийн үед чагнахад хоёр уушгины арын доод хэсгээр нойтон хэрчигнүүр сонсогдож байвал зүрхний цочмог дутагдлын (Киллипийн ангилалаар) хэд дүгээр зэрэг байж болох вэ?

A. I зэрэг

B. II зэрэг

C. III зэрэг

D. IV зэрэг

E. V зэрэг

/46./ Дараах оношлогооны аргуудаас аль нь миокардын ишемийг эрт оношлох боломжтой вэ?

A. Зүрхний цахилгаан бичлэг

B. Зүрхний хэт авиан шинжилгээ

C. Анамнез

D. Зүрхний ачаалалтай бичлэг

E. Сийвэнд фермент үзэх

/47./ Эмнэл зүйн ямар хэлбэрийн перикардитийн үед цээжний өвдөлт ба перикардын шүргэлцэх чимээ илэрдэг вэ?

A. Цочмог перикардит

B. Хуурай перикардит

C. Шүүдэст цочмог перикардит

D. Шүүдэст архаг перикардит

E. Наалдаст перикарди

/48./ Дараах антиангиналь эмүүдээс аль нь судас тэлэх үйлчилгээтэй вэ?

1. Каптоприл

2. Амлодипин

3. Атенолол

4. Нитросорбид

5. Кордарон

/49./ Ямар хүмүүс халдварт эндокардит өвчинд өртөмтхий вэ?

1. Хиймэл хавхлага суулгасан

2. Хар тамхи хэрэглэдэг

3. Гемодиализ хийлгэдэг

4. Митрал хавхлагын унжилттай

5. Гүйлсэн булирхайн үрэвсэлтэй

/50./ Зүрх судасны өвчний ерөнхий эрсдлийг тодорхойлохын тулд танд ямар мэдээлэл хэрэгтэй вэ?

1. Артерийн даралтын түвшин

2. Цусан дахь холестерин хэмжээ

3. Цусан дахь глюкозын хэмжээ

4. Тамхи татдаг эсэх

5. Нас

/51./ Зүрхний архаг дутагдалд хамаарах зөв хариултыг сонгоно уу?

1. Тархалт нь нас ахих тутам ихэсдэг

2. Систолын дутагдал нь илүү тохиолддог

3. Хөгжиж буй орнуудад зүрхний олдмол гажиг нь гол шалтгаануудын нэг болдог

4. Зүрх судасны гаралтай нас баралтын гол шалтгааны нэг мөн

5. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үндсэн шалтгааны нэг

/52./ ST сегмент өргөгдөөгүй зүрхний шигдээстэй өвчтөнд эрсдлийн зэргийг тодорхойлох нь ямар ач холбогдолтой вэ

1. Онош тодруулах
2. Эмчилгээ сонгох
3. Хүндрэлийг илрүүлэх
4. Тавиланг урьдчилан тодорхойлох
5. Өвчний явцыг үнэлэх

/53./ Зүрхний цочмог шигдээсийн эмгэг жамын гол механизм нь титэм судасны фиброзон товрууны задрал гэж үздэг. Товруу задарснаас тромбоцитын агрегаци ихсэж, бүлэн үүснэ.

/54./ Архаг миелолейкоз эмгэгийн үед захын цусны шинжилгээнд голчлон илэрдэг өвөрмөц өөрчлөлтийг сонгоно уу

- A. Гумпрехтийн сүүдэр
- B. Базофиль-эозинофилийн холбоо
- C. Лейкемийн цонх
- D. Улаан эс нулимсны дусал хэлбэртэй болох
- E. Өрсөн зоосны шинж

/55./ Нугасны усны шинжилгээнд ямар өөрчлөлт илэрвэл Нейролейкеми гэж үзэх вэ?

- A. 1 мкл нугасны усанд 20-с дээш цитоз илэрвэл
- B. Нугасны усанд Пандийн урвал эерэг гарвал
- C. 1 мкл нугасны усанд 10-с дээш цитоз илэрвэл
- D. Нугасны усанд цусны дүрст элементүүд орж ирсэн байвал
- E. Нугасны ус даралт ихтэй, өнгөн нь өөрчлөгдсөн байвал

/56./ Идиопатик тромбоцитопенийн үед дараахь шинжийн аль нь илрэхгүй вэ?

- A. Дэлүү авах нь үр дүнтэй
- B. Ясны хэмэнд мегакариоцитын тоо ихсэнэ
- C. Ig G –н титр ихсэнэ
- D. Панцитопени илрэнэ
- E. Тромбоцит хэмжээгээр томорно

/57./ Цочмог миелобластын лейкоемийн /ЦМЛ/ оношлогооны гол үзүүлэлт юу вэ?

- A. Миелограммд илрэх бластын тоо 20%-иас их байх
- B. Өмнө нь Вит В12 дутагдлын цус багадалт оношлогдож байсан өвчтөн
- C. Захын цусны түрхэцэнд илрэх бластын тоог 15%-иас их байх
- D. Цитогенетикт Ph хромосом илэрсэн байх
- E. Лейкограммд цагаан эсийн зүүний хазайлт илрэх

/58./ Глюкоз-6-фосфатдегидрогеназын дутагдал илэрхий хурц явагддаг хэлбэрийг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Фавизм
- B. Г-6-фосфатдегидрогеназапати
- C. Вальденстромын өвчин
- D. Плейхроми
- E. Маркиав-Микелийн өвчин

/59./ Шууд үйлчлэлтэй тромбины ингибиторт аль эм орох вэ?

1. Эноксапарин
2. Лепирудин
3. Данапаройд
4. Аргатробан
5. Фондапаринукс

/60./ Доорх өөрчлөлтүүдээс аль нь архаг миелолейкозын даамжралын шатанд орсныг илтгэх вэ?

1. Даамжирсан тромбоцитоз
2. Хромосомын нэмэлт гаж өөрчлөлтүүд илрэх
3. Ясны улаан чөмөгний эсийн шинжилгээнд бласт эсийн тоо ихсэх (≥ 10) шинжилгээнд
4. Трепанобиопси-д өөхний эсүүд ихээр илрэх
5. Лейкоцитийн тоо ихэвчлэн 150 мянгаас дээш болох

- /61./ Монгол улсад эх барихын эмэгтэйчүүд судлалаар анхны эрдэмтэн хэн бэ?
- М.Дамбадорж
 - Б.Жав
 - Д.Ичинхорлоо
 - Ч.Шагдар
 - С.Дорж
- /62./ Хэвийн явцтай жирэмсэн үед ямар шинжилгээг заавал хийх шаардлагагүй вэ?
- Серологийн сорил
 - Цусны резус-фактор
 - Гемоглобины хэмжээг тогтоох
 - Цэлмэнгийн ганодотропин даавар тодорхойлох
 - Наалдац болон эсийн шинжилгээ
- /63./ Ургийн уушигны хөгжлийг сайжруулах зорилгоор хийх эмчилгээнд аль нь хамаарах вэ?
- Сульфат магни
 - Агчил тавиулах
 - Глюкокортикоид
 - Кальц хлорид
 - Даралт бууруулах эм
- /64./ Жирэмсэн үед эмэгтэйн цусанд гарах физиологийн өөрчлөлтийг нэрлэ:
- Тромбоцитийн тоо цөөрнө;
 - Ургийн хэмжээ багасана;
 - Эргэлдэх цусны хэмжээ 35-40% нэмэгдэнэ;
 - Цагаан эсийн тоо цөөрнө
 - Трансаминаз өснө
- /65./ Хүнд хэлбэрийн цус багадалттай жирэмсэн эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
- Цус сэлбэх боломжтой газар төрүүлнэ
 - Төмрийн бэлдмэлийг 2 шахмалаар 3 сар уулгана
 - Эмнэлэгт яаралтай шилжүүлнэ
 - Яаралтай төрүүлнэ
 - Хэврийн дэглэмд байлгана
- /66./ Жирэмслэхээс хамгаалах дааврын хавсарсан эмийг хэзээ хэрэглэх вэ?
- Биений юмны дунд үед
 - Биений юм ирсэн 7 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
 - 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа булчинд тарина.
 - Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
 - Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.
- /67./ Улаан хоолой гэмтэх үед гарах гол шинжийг нэрлэнэ үү?
- Юмзалгихад сааталтай
 - Хоолой хоржигнож дуугарна.
 - Халуурна
 - Бөөлжинө
 - Хүзүүний арьсан дор хий хурна.
- /68./ Өрц гэмтсэн үед амьсгал бүтэх магадлалыг заана уу.
- 10%-аасбага
 - 20-40%
 - 41-60%
 - 61-80%
 - 81%-иасдээш
- /69./ Наалдаст түгжрэлийн эхэн үед ямар шинж илрэхгүй вэ?
- Хэвлийгээр байнга өвдөх
 - Хэвлийгээр базалж өвдөх
 - Бөөлжих
 - Гэдэс дүүрэх
 - Хий, өтгөн гарахгүй болох
- /70./ Өвчтөн осолдон байранд тусламж үзүүлж эхлэхээс өмнө заавал гүйцэтгэх ямар үйлдэл шаардлагатай вэ?

- A. Өвчтөнийг зөв байрлуулах
- B. Ослын гэрчээс асуух
- C. Тусламж дуудах
- D. Ослын орчныг үнэлэх
- E. Анхны тусламжийн цүнхээ шалгах

/71./ Амин эрхтэнд хамаарахыг нь сонгоно уу?

- 1. Амьсгалын зам
- 2. Амьсгалалт
- 3. Цус эргэлт
- 4. Элэг
- 5. Бөөр

/72./ Өвчтөн А 64 настай, элэгний хорт хавдартай ба хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд сул шингэн тогтоогдсон тул Спиринолактон 3 сарын турш 100 мг-аар ууж, одоо 200 мг-аар буюу 8 шахмалаар өглөө бүр уудаг болсон. Түүний хэвлийн тойрог 72 цагийн дараа үзэхэд 3 см-ээр буурсан байв. Одоо ямар арга хэмжээ авах вэ?

- A. Эмчилгээг үргэлжлүүлэх ба Спиринолактоныг 200- 300 мг-аар өглөө бүр уулгах
- B. 200 мг Спиринолактоныг 40 мг Фуросемидтэй хавсарч уулгах
- C. Фуросемид 40 мг-аар уулгах
- D. Фуросемид 80 мг-аар уулгах
- E. Парацентез хийх

/73./ Өвчтөн К ходоодны хорт хавдрын хүчтэй өвдөлттэй байсан тул Морфин ууж эхэлсэн. Гэтэл Морфин уусан өдрөөс түүний дотор муухайрч бөөлжих болсон. Түүний бөөлжилтийг намдаахад ямар эм сонгомол үйлчилгээтэй вэ?

- 1. Допамины эсрэг эм
- 2. Гистамины эсрэг эмийн бүлэг
- 3. Галоперидол
- 4. Серотонины эсрэг Ондансетрон
- 5. Димедрол

/74./ Баруун үе үе татагнаж булчин татна. Аажмаар суларч, явахад чирэгдэнэ. Бабинскийн рефлекс баруунд тод. Өвдөг, борвины рефлекс өндөр $d>s$.

- A. өмнөд төв атираа зүүнд
- B. арын төв атираа зүүнд
- C. нугасны арын эвэр L1-L5
- D. нугасны өмнөд эвэр L1-L5
- E. нугас талласан L1-L5

/75./ Бага тархины бүтцүүд

- 1. Nucleus dentatus
- 2. Tr. Spino-cerebellar
- 3. Vermis
- 4. Tr. reticulo-spinal
- 5. Tr. Bulbo-spinal

/76./ Сүрьеэгийн нян илрүүлэх цэрний түрхэцийг Циль-Нильсены аргаар будах үед сүрьеэгийн савханцарын ямар шинжийг ашиглаж байна вэ?

- A. Гадаад орчинд тэсвэртэй шинж
- B. Хүчилд тэсвэртэй шинж
- C. Сөрөг хэмд тэсвэртэй шинж
- D. Хувирамтгай шинж
- E. Дээрхи бүгд

/77./ Сорвит хөндийт сүрьеэгийн намжмал байдлын үед халдвар тараахгүй гэдгийг батлах гол шалгуур үзүүлэлтийг нэрлэнэ үү?

- A. Хордлогын хам шинж намжих
- B. Гэрлийн шинжилгээнд эерэг өөрчлөлт илрэх
- C. Цэрний түрхэцийн шинжилгээнд сөрөг буюу сүрьеэгийн нян илрэхгүй байх
- D. Уушиг-гуурсан хоолой гялтангийн хам шинж бүдэгрэх
- E. Дээрхи бүгд

- /78./ Уушигны сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэгүүдийг тоочно уу?
1. 21 хоногоос дээш хугацаанд ханиах
 2. Цэр, цустай цэртэй ханиах
 3. Цээжээр өвдөх
 4. Халуурах, хөлрөх
 5. Турах
- /79./ Хүүхдийн анхдагч сүрьеэгийн оношлогоонд өргөн хэрэглэх шинжилгээний аргуудыг тоочно уу?
1. Цусанд уургийн хэмжээг тодорхойлох
 2. Туберкулины сорил
 3. Цэрний түрхэцийн шинжилгээ
 4. Уушгины гэрлийн шинжилгээ
 5. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ
- /80./ Вирүст С гепатитын халдварын эх уурхайг тэмдэглэ.
- A. Халдвартай цус плазма
 - B. Өвчтэй хүн ба вирус тээгч
 - C. Өвчтэй амьтад
 - D. Бохирлогдсон зүү, тариур
 - E. Бэлгийн зам
- /81./ Тархины цочмог хавангийн 3-р зэргийн үед цусны pCO_2 -ийн хэмжээ дараахь байдалтай байна.
- A. Хэвийн
 - B. Багасана
 - C. Ихэсэнэ
 - D. Янз бүрийн хэмжээнд
 - E. Хэт багасна.
- /82./ Цочмог цусан суулгын колитын хэлбэрийн үед ямар шинжүүд илрэх вэ?
1. Өвчний эхлэл хурц
 2. Хий дүлнэ
 3. Хэвлийн доод хэсгээр базалж өвдөнө
 4. Ус ихтэй суулгана
 5. Маш их хөстэй
- /83./ Урвах тахлын эгэл бус хэлбэрүүдийг тэмдэглэ.
1. Өндөр настай хүмүүст
 2. Хуурай хэлбэр
 3. Жирэмсэн эмэгтэйд
 4. Цахилгаан хэлбэр
 5. Бага насны хүүхдэд
- /84./ Нүдний дотоод шингэн хаанаас үүсдэг вэ?
- A. Болорын арын капсулаас
 - B. Сормосовчийн сэртэнгээс
 - C. Шиллэг биеээс
 - D. Хүүхэн харааны дотно ирмэгээс
 - E. Шүдлэг зурваснаас
- /85./ Аль нүдний гидродинамикийн үзүүлэлт вэ?
1. Шингэний үүсэн гарах хурд
 2. Нүдний дотоод даралт
 3. Нүднээс урсан гарах хурд
 4. Урсгалын даралт
 5. Нүдний шингэний 1 минутын хэмжээ
- /86./ Харааны мэдрүүлийн хаван үүсгэсэн шалтгаанаас хамааран хэрхэн ангилдаг вэ?
1. Анхдагч
 2. Халдварын
 3. Хоёрдогч
 4. Харшлын
 5. Удамшлын

/87./ 0-1 насны хүүхдийн чихийг шинжлэх хамгийн тохиромжтой рентген шинжилгээ аль нь вэ?

- A. Шюллерийн арга
- B. Майерийн арга
- C. Стенверсийн арга
- D. Гинзбургийн арга
- E. КТ

/88./ Чихэнд гадны биет байхад илрэх шинжүүд аль нь вэ?

- 1. Чихээр өвдөх
- 2. Чихэнд юм байгаа мэт мэдрэмж төрөх
- 3. Сонсгол буурах
- 4. Амтлахуй алдагдах
- 5. Дайвалзах

/89./ Хамрын үзүүр, угалз хэсгийн тосны булчирхайн цорго битүүрч, батга өтгөрч, орчны цусны хялгасан судсууд холбогч эдтэй наалдан, хамар хэмжээгээрээ томрох эмгэгийг “боргоцой хамар” гэх (1) бөгөөд үүнийг зөвхөн мэс заслаар л эмчилнэ

/90./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөг рүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьеэгийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар эмчилгээ илүү үр дүнтэй вэ?

- A. Антибиотик
- B. Даавар эмчилгээ
- C. Сүрьеэгийн эсрэг эмчилгээ
- D. Аллопуринол эмчилгээ
- E. Гепарин эмчилгээ

/91./ Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ хэрхэн өөрчлөгддөг вэ ? Энэ нь ямар үр дагавартай вэ ?

- 1. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ багасдаг тул цус өтгөрдөг, биеийн жин багасдаг
- 2. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ багасдаг тул арьс хуурайшиж, үрчийдэг.
- 3. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ багасдаг тул гэдэс, ходоодны шүүрэл багасч, хоол боловсруулалт мууддаг.
- 4. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ ихэсдэг тул даралт ихсэх хандлагатай байдаг.
- 5. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ ихэсдэг тул тархи хавагнах ба тэнэгрэл, зөнөгрөл болох хандлагатай байдаг.

/92./ Настан бусдаас хамааралгүй өөртөө үйлчлэх бүрэн чадвартай болохыг яаж мэдэх вэ?

- A. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 1
- B. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 6 ба түүнээс дээш
- C. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 5
- D. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 4
- E. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 0-6

/93./ Зүрхний шигдээсийн үед өрхийн эмчийн менежмент

- 1. Титэм судсыг өргөсгөх эмчилгээ хийнэ: Нитроглицериныг 15 минутын зайтай хэлэн дор тавина.
- 2. Өвдөлт намдаах эмийг тарина: Морфин эсвэл Трамадол.
- 3. Гараа эмчилгээг хийсний дараа эмнэлэгт яаралтай биечлэн түргэний машинаар хүргэж өгнө.

4. Эмнэлэг хүрэх замд АД, пульсийг байнга шалгаж байна
5. Хэрэв дарал буурах хандлагатай байвал шокийн индексийг тогтоогоод эмнэлэг хүрэх замын турш калитай глюкозыг судсаар дуслаар хийнэ.
- /94./ Үений гулсах замын үрэвслийн эмгэгжамын бүтэц эвдрэх үед гарахгүй өөрчлөлтийг нэрлэнэ үү.
- A. Үений уутанд хаван их хэмжээгээр үүснэ.
- B. Фибрин ихээр хуримтлагдана.
- C. Үрэвслийн шингэн иасралтгүй нэмэгдэнэ.
- D. Үений уут улаан хөхөлбөр өнгөтэй болж ирнэ.
- E. Үений бүрхүүлийн эргэн тойрон дахь бүтэц эвдэрнэ.
- /95./ Бөөрөөр шээсний хүчлийн ялгаралтыг багасгаж улмаар гиперурикеми үүсгэдэг эмийн бэлдмэлийг нэрлэнэ шүү.
1. Тиазидууд
2. Никотины хүчил
3. Аспирин бага тунгаар
4. Лазикс
5. Этамбутол
- /96./ ОА-ийн үеийн эрт үед рентгенд илрэх өөрчлөлт
1. Ясны сийрэгжилт
2. Ясны ургалт байхгүй
3. Радиологийн завсар үүсэх
4. Үе хоорондын зай бага зэрэг нарийсах
5. Мөгөөрсний үхжил
- /97./ Эрхтэн тогтолцооны чонон ярын үед мэдрэлийн талаас ямар өөрчлөлт гарч болдог вэ:
1. Таталт
2. Булчин хатингарших
3. Солиорол
4. Гурвалсан мэдрэлийн эмгэг
5. Миелопати, нугасны гэмтэл
- /98./ Эрхтэн тогтолцооны чонон хөрвөсний оношлогооны шалгуурт аль нийцэхгүй вэ:
1. Үс унах, алопеция
2. Арьсан доорхи товруу
3. Үений өвдөлт
4. Цагираг улайлт
5. Нарны хэт ягаан туяанд мэдрэг болох
- /99./ ANA ямар тохиолдолд үед эерэг гарч болдог вэ:
1. Элэгний С вирусний гепатит
2. Эрхтэн тогтолцооны чонон хөрвөс
3. Ревматоид артрит
4. Эрхтэн тогтолцооны хатуурал
5. Халдварын үед
- /100./ Ревматоид артритын даамжрах үед рентгенд үений гадаргуу гөлийх ба үүсэх ба харин яс үений үрэвслийн даамжрах үед рентгенд үений зай нарийсах, мөгөөрсний доорх хатуурал үүссэн байдаг.

Сорилын зөв хариулт

1-B, 2-B, 3-B, 4-E, 5-A, 6-A, 7-C, 8-B, 9-A, 10-A, 11-E, 12-C, 13-D, 14-D, 15-D, 16-A, 17-D, 18-E, 19-C, 20-E, 21-D, 22-B, 23-D, 24-C, 25-B, 26-C, 27-C, 28-E, 29-E, 30-D, 31-C, 32-B, 33-A, 34-D, 35-D, 36-E, 37-B, 38-E, 39-E, 40-E, 41-D, 42-A, 43-A, 44-E, 45-B, 46-D, 47-B, 48-C, 49-A, 50-E, 51-E, 52-C, 53-A, 54-B, 55-C, 56-D, 57-A, 58-A, 59-C, 60-A, 61-A, 62-D, 63-C, 64-A, 65-A, 66-D, 67-E, 68-B, 69-A, 70-D, 71-A, 72-A, 73-B, 74-A, 75-A, 76-B, 77-C, 78-E, 79-C, 80-B, 81-D, 82-A, 83-C, 84-B, 85-E, 86-B, 87-D, 88-A, 89-C, 90-C, 91-A, 92-B, 93-E, 94-D, 95-E, 96-A, 97-B, 98-A, 99-E, 100-D,